



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 15/10

Сайншанд сум

Дуудлагаар худалдах аргаар
хувьчлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2.3, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн “Эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, хувийн өмчлөлд шилжүүлэх зорилгоор нээлттэй дуудлагаар худалдах аргаар хувьчилсугай.

2. Дорноговь аймгийн “Эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон зогсоож, ОНӨААТҮГ-ын эд хөрөнгөд мэргэжлийн байгууллагаар эд хөрөнгийн үнэлгээ хийлгэж, нээлттэй дуудлагаар худалдах ажлыг зохион байгуулан, дуудлага худалдааны орлогоос тухайн газрын өр төлбөрийг барагдуулж, хуулийн этгээдийг татан буулгаж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д даалгасугай.

3. Тус ОНӨААТҮГ-ын эд хөрөнгийг дуудлагаар худалдах зарыг олон нийтэд нээлттэй мэдээлж, худалдан авсан этгээдтэй гэрээ байгуулан, эд хөрөнгийг хүлээлгэн өгч, газрыг татан буулгах ажлыг зохион байгуулахыг аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Мөнх-Эрдэнэ), “Дорноговь аймгийн эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Жамъянжав), Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (О.Батжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг 2024 оны 4 улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсөв, санхүү эдийн засгийн хөгжлийн хорооны ахлагч (Б.Хүдэрболд), аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

6. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 07/14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ

442230144